Сонгинохайрхан дүүргийн Эрүүл мэндийн төвийн
даргын 2025 оны 05 дугаар сарын 15 ны өдрийн
А/43 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт

# АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫН МАЯГТ

## I.ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан үндэслэл:

☐ Төрийн албаны тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан шинэчлэн боловсруулсан

☐ Хууль тогтоомжоор байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон

| | |
|---|---|
| Холбогдох хууль тогтоомжийн нэр, огноо: | Төвийн даргын А/43 тоот тушаал |
| Дагаж мөрдөх огноо: | 2025.05.15 |
| Албан тушаалын тодорхойлолтыг баталсан огноо: | 2025.05.15 |

| | |
|---|---|
| Байгууллагын нэр: | Нэгжийн нэр: |
| СХДЭМТ | Дотоод хяналтын алба |
| Албан тушаалын нэр: | Албан тушаалын ангилал, зэрэглэл: |
| Дотоод хяналтын албаны дарга | ТҮЭМ-7 |
| Ажлын цаг: | Ажлын байрны албан ёсны байршил: |
| 8 цаг | СХД 13 хороо Залуус гудамж |
| Хөдөлмөрийн нөхцөл: | Онцгой нөхцөл: |
| Хэвийн | - |

## II. АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ

Эрүүл мэндийн төвийн үйл ажиллагаатай холбоотой хууль эрх зүйн акт, бодлогын баримт бичигт тусгагдсан заалт, зорилт, арга хэмжээний хэрэгжилт нь төлөвлөсөн үр дүнд хүрсэн эсэх, хяналт хийх, дүгнэлт, зөвлөмж гаргах, үйл ажиллагааны төлөвлөлт, тайлагналт, гүйцэтгэлд дотоод хяналт шалгалтыг хийж цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний санал гаргах, удирдлагыг бодитой мэдээллээр хангах, алдаа зөрчлийг арилгах, урьдчилан сэргийлэх талаар мэргэжил арга зүйгээр хангах

**Албан тушаалын зорилт:**

1. Байгууллагын үйл ажиллагааны хүрээнд дотоод хяналтын чиг үүргийг хэрэгжүүлэх, зохих удирдамж, төлөвлөгөөний дагуу дотоод хяналт шалгалтыг гүйцэтгэж, хяналт шинжилгээ, үнэлгээ хийх, дүгнэлт зөвлөмж гаргах, үр дүнг тайлагнах
2. Байгууллагын үйл ажиллагаатай холбоотой бодлогын баримт бичиг, дээд газрын тушаал шийдвэр, үүрэг даалгаврын биелэлт, хэрэгжилт, төлөвлөгөөний биелэлтэнд дүн шинжилгээ хийх
3. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний оношилгоо, эмчилгээ, түгээмэл үйлдлийн стандарт, удирдамжийн хэрэгжилтэд Чанарын албатай хамтран дотоод хяналт үнэлгээг хийн дүгнэлт гарган ажиллах
4. Байгууллагын өмч хөрөнгийн бүртгэл тооцоо, ашиглалт, хадгалалт, хамгаалалт, шилэн дансны журмын хэрэгжилтэд хяналт тавих,
5. Чанарын менежментийн тогтолцоо ISO9001:2015 стандартын хэрэгжилтийг хангах
6. Бусад

| Зорилт | Албан тушаалын гүйцэтгэх чиг үүрэг | Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт | Хариуцлага, оролцооны хэлбэр Туслах - Т, Хариуцан гүйцэтгэх - Г Хянах – Х Шийдвэрлэх – Ш |
|---|---|---|---|
| 1 дүгээр зорилтын хүрээнд | 1. Дотоод хяналт шалгалтын төлөвлөгөө, хуваарийг боловсруулж батлуулах, хяналт шалгалтыг батлагдсан удирдамжийн дагуу зохион байгуулах, хяналт үнэлгээ хийх, дүгнэлт гаргах<br>2. Хяналт шалгалтын явцад илэрсэн зөрчлийг арилгах, урьдчилан сэргийлэх талаар мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх, зөрчил, дутагдлын шалтгаан нөхцөлийг тодруулан зөрчлийг арилгуулах, дахин гаргуулахгүй байх талаар арга хэмжээ авах<br>3. Тасаг, нэгжээс шаардлагатай мэдээ, судалгаа гаргуулах, холбогдох ажилтны ажлыг шалгаж танилцах, илэрсэн зөрчил, дутагдлын талаар тайлбар гаргуулах<br>4. Зөрчил, дутагдлын шалтгаан, нөхцөлийг арилгах зорилгоор зөрчил гаргасан ажилтанд хариуцлага ногдуулах талаар байгууллагын удирдлагад санал тавьж шийдвэрлүүлэх<br>5. Хийсэн хяналт шалгалтын талаар бүртгэл хөтөл, мэдээллийн сан | Батлагдсан төлөвлөгөөний дагуу хяналт үнэлгээ хийгдсэн тоо, дүгнэлт, зөвлөмж гарна Илэрсэн зөрчлийн тоо буурна<br><br>Мэдээллийн сантай болно<br><br>Тогтоол шийдвэрийн биелэлт хангагдана<br><br>Сахилга хариуцлага дээшлэнэ. | 1. Г<br>2. Х<br>3. Х<br>4. Г<br>5. Х |
| 2 дугаар зорилтын хүрээнд | 1.Холбогдох хууль тогтоомж, тогтоол шийдвэр, нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон эрхзүйн акт, албан даалгаварын биелэлтийг нэгтгэн, дүгнэн, биелэлтэнд дүн шинжилгээ хийж ажиллах<br>2. Поликлиник амбулатори,Дэмжих төв, Тасаг нэгжийн төлөвлөгөөний биелэлт, хэрэгжилт үр дүн, дотоод хяналтын чиг үүрэгт хяналт үнэлгээ, шинжилгээ хийх, дэмжлэгт мэргэжил арга зүйгээр хангах<br>3. Байгууллагын дотоод журмын мөрдөлт, эмч, эмнэлгийн мэргэжилтний ёс зүй, ажлын байрны цаг ашиглалт, санал гомдол, сэтгэл ханамжийн байдалд хяналт тавих | Хяналт үнэлгээ хийсэн тоо, илрүүлсэн зөрчил түүний мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээ үр дүн<br><br>Хөндлөнгийн хяналт, шалгалтаар бага эрсдэлтэй гарах | 1. Г,Х<br>2. Г,Х<br>3. Г,Х |

| | | | |
|---|---|---|---|
| 3 дугаар зорилтын хүрээнд | 1.Хүн амд үзүүлж байгаа эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, аюулгүй байдал, халдварын сэргийлэлт, эмийн хадгалалт, зарцуулалт, баталгаажилт зэрэгт хяналт тавих<br><br>2.Эмнэлгээс шалтгаалах халдвараас сэргийлэх үйл ажиллагаа, хог хаягдлын менежментэд хяналт тавих, халдвар хяналтын багийн ажлын гүйцэтгэлд хяналт үнэлгээ хийж үйл ажиллагааг тогтмолжуулах<br><br>3.Хөдөлмөр хамгаалал, эрүүл ахуй, аюулгүй байдал, багаж тоног төхөөрөмжийн баталгаажилт, техник ашиглалтын паспорт хөтлөлт, аюулгүй ажиллагааны зааврын хэрэгжилт, галын аюулгүй байдлын бэлэн байдалд хяналт тавих | Ажлын гүйцэтгэл | 1. Х<br>2. Х<br>3. Х |
| 4 дугаар зорилтын хүрээнд | 1.Байгууллагын өмч хөрөнгийн бүртгэл тооцоо, ашиглалт, хадгалалт, хамгаалалтад хяналт шалгалт хийх<br><br>2.Байгууллагын үйл ажиллагааны ил тод байдал, Шилэн дансны журмын хэрэгжилтэд үнэлгээ хийж хяналт тавих, шинэчлэлийг тогтмолжуулах<br><br>3.Хөндлөнгийн хяналт, шалгалтын үнэлгээ дүгнэлт, Магадлан итгэмжлэх, зөвлөмжийн хэрэгжилтийг хангах ажлыг эрчимжүүлэх, явцын дотоод, хяналт үнэлгээ хийх | Ажлын гүйцэтгэл | 1. Х,Ш<br>2. Х<br>3. Х |
| 5 дугаар зорилтын хүрээнд | 1. Байгууллагын чанарын удирдлагын тогтолцоог (ISO 9001:2015 стандарт) хэрэгжүүлж, тасралтгүй сайжруулахад манлайлал үзүүлэх.<br><br>2. Стандартын хэрэгжилтэнд хянаж, тавьж, сайжруулах үйл ажиллагааг зохион байгуулах<br><br>3. Чанарын удирдлагын баримт бичиг болон бүртгэлтэй танилцах, хэрэгжүүлэх, шинэчлэлд оролцох, хэрэгжилтийг хянах.<br><br>4. Дотоод аудитыг удирдан зохион байгуулж шаардлагатай мэдээлэл, нотолгоог бүрдүүлэх. | Ажлын гүйцэтгэл | 1. Г, Т<br>2. Г, Х<br>3. Г, Х<br>4. Г, Х<br>5. Г, Х<br>6. Х, Т |

| | | | |
|---|---|---|---|
| | 5. Байгууллагын эрсдэл, боломжийг тодорхойлох, арга хэмжээ төлөвлөх, хэрэгжилтийг хангахад дэмжлэг үзүүлэх<br>6. Сайжруулалтын санал гаргах, гүйцэтгэлийг хянах, үр дүнг сайжруулах ажлыг манлайлах. | | |
| Бусад зорилтын хүрээнд | 1. Удирдах албан тушаалтны шийдвэрээр гамшиг, осол, онцгой нөхцөл байдлын ( халдварт өвчин, цар тахал, байгалийн аюулт болон гамшигт үзэгдэл) үед дайчлагдан ажиллах үүрэгтэй.<br>2. Үйлчлүүлэгчийн аюулгүй ажиллагааг ханган ажиллах<br>3.Ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгслийг зориулалтын дагуу хэрэглэж, хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны зааварчилгааг чандлан сахин, хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн тухай хуулийн хүрээнд ажиллана.<br>4.Эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар, стандартыг мөрдөн ажиллах, чанар сайжруулах чиглэлээр идэвх, санаачлагатай ажиллах. Чанарын албанаас өгсөн үүрэг даалгавар болон сургалт үйл ажиллагаанд идэвхитэй оролцох. | Ажлын гүйцэтгэл, оролцсон арга хэмжээ | 1. Г<br>2. Г<br>3. Г<br>4. Г |

| III.АЛБАН ТУШААЛД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА | |
|---|---|
| **Боловсрол** | Анагаах ухааны,Санхүүгийн,хуулийн боловсрол олгох их, дээд сургууль төгссөн дээд боловсролтой |
| **Мэргэжил** | Хүний их эмч ,Эдийн засагч, Эрх зүйч |
| **Мэргэшил** | |
| **Туршлага** | 5-с доошгүй жил ажилласан байх |
| **Гадаад хэл** | Англил хэлний анхан дунд түвшингээс доошгүй мэдлэгтэй |
| **Компьютерийн мэдлэг** | Хэрэглээний праграм бүрэн ашиглах<br>Интернэтийн орчин,дотоод сүлжээнд чөлөөтэй ажиллах |
| **Судалгааны арга зүй** | Статистик шинжилгээ хийх |
| **Ур чадвар** | • Хууль эрх зүйн мэдлэгтэй байх<br>• Багаар ажиллах<br>• Яриа харилцаа хувийн соёлтой байх<br>• Манлайлах<br>• Гүйцэтгэлд хяналт тавих,үнэлгээ хийж дүгнэлт гаргах чадвартай байх |
| **Албан тушаал эрхлэгчийн хүлээх хариуцлага** | Ажлын байрны үндсэн чиг үүрэгт заасан үйл ажиллагаатай холбоотой асуудлыг ЭМТ-ийн даргын өмнө хариуцна. |

| IV.АЛБАН ТУШААЛТНЫ ХАРИЛЦАХ СУБЪЕКТ | |
|---|---|
| Албан тушаалыг шууд харьяалан удирдах албан тушаалын нэр:<br>Эрүүл мэндийн төвийн дарга, Орлогч дарга нар | |
| 1.Албан тушаалд шууд харьяалан удирдуулах албан тушаалын нэр, тоо Эмнэлгийн дотоод хяналт шинжилгээ, үнэлгээний албаны орон тооны болон орон тооны бус гишүүд, бусад эмч, эмнэлгийн мэргэжилтэн, ажилчид | Бусад харилцах субъект<br>ЭМЯ, МХХ, Магадлан итгэмжлэлийн зөвлөл, НЭМГ, ДЗДГазар, ӨЭМТ-үүд, бүх шатлалын эмнэлгүүдийн дотоод хяналт шинжилгээ, үнэлгээ асуудал хариуцсан мэргэжилтнүүд |

| V.АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ | |
|---|---|
| **Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан:** | **Албан тушаалын тодорхойлолтыг баталсан:** |
| Байгууллагын нэр: Сонгинохайрхан дүүргийн Эрүүл мэндийн төв<br>Албан тушаал: Хүний нөөцийн менежер<br><br>.............................. Батболдын Мичидмаа<br>(Гарын үсэг) (Эцэг/эх/-ийн нэр, өөрийн нэр)<br><br>202.... оны.....дугаар сарын......-ны өдөр | Байгууллагын нэр: Сонгинохайрхан дүүргийн Эрүүл мэндийн төв<br>Албан тушаал: Сонгинохайрхан дүүргийн эрүүл мэндийн төвийн дарга<br><br>.............................. Чойжилсүрэнгийн Өнөрсайхан<br>(Гарын үсэг)(Эцэг/эх/-ийн нэр, өөрийн нэр)<br>202.....оны.......дугаар сарын.........-ны өдөр |